



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийг данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.4, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Биеийн тамир, спортын улсын хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 23,356,666.57 (хорин гурван сая гурван зуун тавин зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг тавин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, 14,734,333.57 (арван дөрвөн сая долоон зуун гучин дөрвөн мянга гурван зуун гучин гурван төгрөг тавин долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Биеийн тамир, спортын улсын хорооны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баттулга, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга М.Баяраа болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээд (Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хороо)-д эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах, ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001041

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ДАНСНААС ХАСАХ, ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Балансын нийт (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хороо							
1	Тоёото хайес (Бага оврын микро автобус)	2006/2015	ш	1	23,356,666.57	14,734,333.57	8,622,333.00
Нийт дүн					23,356,666.57	14,734,333.57	8,622,333.00